




АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2019 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН ТӨВ

Авлигатай тэмцэх газар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, 2019 онд дэвшүүлсэн зорилтыг ханган биелүүлэх чиглэлээр дараахь ажил, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа.



Ажлын албан ёсны тайлангаас онцлон, товчлон танилцуулж байна.



АТГ-ын 2019 оны дэлгэрэнгүй тайланг <https://iaac.mn/news/awligatai-temtsekh-gazriin-2sh19-onii-uil-ajillagaanii-tailan?menu=59> холбоосоор нэвтэрч үзнэ үү.

**ХӨРӨНГӨ
БУЦААХ
СҮЛЖЭЭНИЙ
ГИШҮҮН
ОРНУУД
УЛААНБААТАРТ
ХУРАЛДАВ**



2019 оны 9 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ (ARIN-AP)-ний Удирдах зөвлөлийн хурал, Бүгд хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулав.

Мөн энэ үеэр Австралийн Дотоод

хэргийн яамтай хамтран хууль бус хөрөнгө буцаах чиглэлээр олон улсын сургалтыг зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд гадаадын 24 улс, олон улсын 5 байгууллагын 70, хууль сахиулах 7 байгууллагын 56 төлөөлөгч буюу нийт 126 хүн оролцов.


АТГ нь Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээний 2019 оны даргалагч улсаар сонгогдон ажиллалаа

**403 АЛБАН ТУШААЛТНЫ
ХОМ-ИЙГ ШАЛГАВ**

2019 онд 403 албан тушаалтны мэдүүлгийг хянан шалгав.

Шалгаж шийдвэрлэсэн ХАСХОМ-ийг өмнөх онтой харьцуулбал илт өссөн байна.

Шалгаж шийдвэрлэсэн



2019

2018

Зөрчлийн улмаас 35 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан нь өмнөхөөс 60 хувиар өссөн үзүүлэлттэй байна

**НИЙТ 1.1 ТЭРБУМ
ТӨГРӨГИЙН ЗӨРЧИЛ
ИЛРҮҮЛЭВ**



Татварын алба болон Нийгмийн даатгалын байгууллага, Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажилласнаар нийт **1.133.194.100** төгрөгийн зөрчлийг илрүүлж, 3 иргэн, 4 аж ахуйн нэгж, байгууллагад **71.043.400** төгрөгийн торгууль ногдуулсан, 1 албан тушаалтныг нийтийн албанаас халах, 2 албан тушаалтанд сануулах сахилгын шийтгэл ногдуулаад байна.

**БИТҮҮМЖЛЭН ХАМГААЛСАН
ХӨРӨНГӨ 62.9 ДАХИН НЭМЭГДСЭН**

12
ИХ НАЯД

Учирсан хохирол

9
ИХ НАЯД

Битүүмжилсэн

11
ТЭРБУМ

Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн

2019 онд гэмт хэргийн улмаас **2.123.202.011.893** төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад **11.343.770.066** төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг **9.736.776.389.079** төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан.

Учирсан хохирлыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 30.6 дахин, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 62.9 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна

**АВЛИГАТАЙ
ТЭМЦЭХЭД
ИРГЭДИЙН
ОРОЛЦОО
ЧУХАЛ**



Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг иргэдэд, оюутан залуучууд, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил гэсэн хэлбэрээр зохион байгуулав.

Үүнд:

- “Үнэт зүйлсийн боловсрол” лекцийн үйл


ажиллагаа

- “Шударга байдал ба олон нийтийн итгэл” хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн
- “Авлигын эсрэг чуулган 2019: Цахим шийдэл” чуулга
- “Албан тушаалтны хөрөнгө орлогод иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх, ХОМ-ийн маягтыг боловсронгуй болгох нь” нээлттэй хэлэлцүүлэг

Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэхэд иргэдийн хүч, оролцоог дайчлан ажиллаж байна

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН 694 ГОМДОЛ ШАЛГАЛАА

2019 онд албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан **694** гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн Шийдвэрлэлт 93.5 хувьтай.



Өнгөрсөн онтой харьцуулахад хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдол **11.5** хувиар өссөн үзүүлэлттэй байна

30 АЛБАН ТУШААЛТНЫ ХОМ-Т ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖ БАЙГАА ЭСЭХИЙГ ШАЛГАЖ БАЙНА

2019 онд 403 албан тушаалтны ХОМ-ийг хянан шалгаснаас Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8-д заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн” байж болох нөхцөл байдал тогтоогдсон

30

албан тушаалтанд холбогдох хяналт шалгалтын материалыг шилжүүлж материалыг шилжүүлж, гэмт хэргийн шинж байгаа эсэхийг нарийвчлан шалгаж байна.



СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨН ХҮРЭЭТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛАВ



● Жүжигчин Б.Амарсайхан, дуучин Д.Отгонжаргал, тамирчин Т.Санчир, хөглөгч Г.Ганхүү нарын оролцсон авлигын гэмт хэргийн эсрэг олон нийтийн оролцоог идэвхжүүлэх, авлигын гэмт хэргийг мэдээлэх 110 дугаарыг олон нийтэд таниулах, авлигын гэмт хэргийн хяналтыг нэмэгдүүлэх зорилго бүхий цуврал видео реклам

● Оюутан залуучуудын дунд “Түлхүүр” уралдаан

● 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Шударга ёс: Хүн болох багаасаа” сэдэвт эссе бичлэгийн уралдаан, “Миний мэдэх шударга ёс” гар зургийн уралдаан

● “Танай хороонд” иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөг

● Гомдол, мэдээлэл хүлээн авах тусгай дугаар 110 утасны хэвлэмэл сурталчилгаа, номын хавчуурга

● Авлигын эсрэг 12 ишлэл афоризм бүхий зурагт хуудас


● Хүүхдүүдэд шударга ёсны зан үйл төлөвшүүлэх “Найзын яриа” комикс номын өдөрлөг

Нийт 17 төрлийн 24.969.000 ширхэг авлигын эсрэг сурталчилгааны материалыг төрийн байгууллага, албан тушаалтан, олон нийтэд хүргэсэн

4 ТӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМ НЭВТРҮҮЛЛЭЭ



2019 онд 8 агентлаг, 5 аймгийн Засаг даргын Тамгын газар, УЕПГ, Улаанбаатар төмөр зам ХНН, Төрийн банк зэрэг 40 байгууллага ХАСУМ-ийн цахим системд бүрэн холбогдоод байна.



Хөнгөн шуурхай, ажил хэрэгч үйлчилгээг бүрэн нэвтрүүлэв

НИЙТ 2104 ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАВ

● АТГ 2019 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас **2104** гомдол, мэдээлэл хүлээн авчээ. Үүний **1137** нь Мөрдөн шалгах хэлтэст хаяглагдсан байна. Нийт гомдлын 54 хувь нь гэсэн үг. Гэмт хэргийн бус зөрчлийн шинжтэй **750** гомдол, мэдээлэл ирсэн.

● 2019 онд бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас **12481** албан бичиг хүлээн авч, бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллагад **11046** албан бичиг илгээж, орон нутгийн шууданд болон бусад албан байгууллагад **13480** бичиг хүргэсэн байна.

Хүлээн авсан бичиг, гомдлын тоо өмнөхөөс 32.5 хүртэл хувиар өссөн дүнтэй байна

АУДИТ БА АРХИВЫН ШАЛГАЛТААР АМЖИЛТТАЙ ДҮГНЭГДЭВ

● Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд явуулсан улсын үзлэгт бэлтгэх ажлыг зохих журмын дагуу хийж хамрагдсанаар **95.0 /А/** үнэлгээтэй үнэлэгдэв.

● Үндэсний аудитын газраас байгууллагын 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтад санхүүгийн анхан шатны баримтыг хамруулан шалгуулсан бөгөөд аудитын байгууллагаас “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛ



ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС
/ТӨЛБӨРГҮЙ/

